

4 сарын мэдээ

Төр захиргааны чиглэлээр:

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллаж байна.

Засаг дарга болон Тамгын газрын дарга, холбогдох албан тушаалтнуудад хандаж 3 өргөдөл гомдол ирж шийдвэрлэгдсэн байна. Шийдвэрлэлт 100 хувьтай.

Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Бүх нийтийн эрхзүйн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг боловсруулан батлууллаа.

Боловсролын чиглэлээр:

Ерөнхий боловсролын багш нар онцгой нөхцөлд сурагчдад хичээлийг хуваарийн дагуу цахимаар орж 7 хоногт 13 багш, 45 цахим хичээл зохион байгуулж, 200 сурагчид хамрагдаж байна.

“Хамтдаа хайрлая-хамтдаа хамгаалъя” сэдэвт цахим уралдааныг бага, дунд ангийн сурагчдын дунд зохион байгуулж байна.

“Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх” сарын аяны хүрээнд төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн.

Цэцэрлэгийн хүүхдүүдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон сургалтын 6 чиглэлээр даалгавар боловсруулан 110 эцэг эхэд өгч хүүхдийнхээ хийж байгааг зураг болон бичлэг болгон бүлгийн цахим хаягт байршуулан эргэх холбоотой ажиллаж байна.

Хүүхдээ сонсох өдрийг угтаж “Ковидын үеийн хүүхэд хамгаалал” сэдвийн дор гар зургийн урлдааныг цахимаар зохион байгуулж нийт 16 хүүхэд оролцлоо.

“Ковидын үеийн хүүхэд хамгаалал” цахим уриалгыг зохион байгуулж 26 хүүхэд оролцлоо.

Мал эмнэлгийн чиглэлээр:

Мал эмнэлгийн дуудлага-2 удаа үйлчилсэн.

Нийтийн эрүүл мэндийн хамгаалах, орчны эрүүл ахуйг сайжруулах, халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 13 аж ахуй нэгж, байгууллагын гадна талбай, 21 айл өрх, нийтийн эзэмшлийн нийт 21.000 кв талбайд ариутгалын ажлыг хийлээ.

Байгаль орчны чиглэлээр:

Хаврын хуурайшилтын үе эхэлсэнтэй холбогдуулан үүсэж болзошгүй ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2-р багийн иргэдэд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж өгч гарын үсгийн баталгааг авч ажиллалаа. Мөн сумын группуудад хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг өгч нийт 2341 хүний хандалттай.

Сумын эрүүл мэндийн төвтэй хамтран аюултай хог хаягдлын цэгийг сумын нэгдсэн хогийн цэгт барьж байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Ажил зуучлалаар 19 иргэнийг, 18 ажил хайгч иргэдийн мэдээллийг сэргээсэн.

ХАБЭА-н зөвлөлийн гишүүдэд “ХАБЭА-н хуулийн танилцуулга” сургалтыг зохион байгуулсан.

Оффисын орчинд ажиллагсдыг "КОВИД-19"-ийн халдвараас хамгаалах зөвлөмж шторкийг 5 төсөвт байгууллагын цахим хаягт байршуулсан.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа хийж асаргааны тэтгэмж сунгуулах 2 иргэн, шинээр асаргаа тогтоолгох 1 иргэний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

4 сарын 20-ны байдлаар 55 иргэнд, 9 чиглэлээр мэдээлэл өгч ажилласан байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үндсэн үзүүлэлтүүд:

- Нийт үзлэг-377
- Амбулаторийн үзлэг-264
- Гэрийн идэвхитэй хяналт-30
- Урьдчилан сэргийлэх-113
- Артерийн гипертензин эрт илрүүлэг-10
- Чихрийн шижин эрт илрүүлэг-10
- Жирэмсний хяналтанд хамрагдсан-11
- Жинэлсэн хүүхдийн тоо-65
- Эмнэлэгт хэвтсэн-12
- Холын дуудлага-18
- Төвийн дуудлага-56

Сэргээн засах:

- Нийт 8 хүнд сэргээн засах хийснээс:
- Нил улаан туяа -5 том хүнд
- УВЧ -3 том хүнд
- УВЧ-2 хүүхэд
- Зөөлөн иллэг-5 том хүнд хийсэн байна.

Хэвтэн эмчлүүлсэн эрчүүдэд “Эрчүүдийн эрүүл мэнд” буюу “Архи тамхи хэтрүүлэн хэрэглэснээр гарах эрсдлүүдийн” талаар сургалт,

“Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийн” хүрээнд хийх ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсэн.

Ахмад настангуудад сувилагч нар гэрийн эргэлт хийж, эргэлтээр “Сүрьеэ эдгэрдэг өвчин” сэдэвт зөвлөмжөөр 10 настанд мэдээлэл хийсэн.

ЕБС-ийн 6р ангийн 28сурагчид “Ус гэж юу вэ?, Усаа хайрлан хамгаалъя” сэдэвт хэлэлцүүлэг,

ЕБС-ийн 7-р ангийн 25 сурагчдад “Гэртээ усаа хэмнэх 16” аргын талаар сургалт,

Төрийн албан хаагчдад “Усны зөв хэрэглээний талаар” сургалт орж сургалтыг бататган алтан хонх тэмцээн зохион байгуулсан.

Гэрийн ажиглалтаас гарч буй иргэдээс 8 дахь хоног дээр түргэвчилсэн шинжилгээ хийж сөрөг гарсан тохиолдолд ажиглалтаас гаргаж нийт-72 түргэвчилсэн хийж бүгд сөрөг гарсан.

Гэрийн ажиглалтанд-12 иргэн байна.

Газрын харилцаа:

Газрын хэмжээ талбай өөрчлөх-1, газар шинээр эзэмших - 2 өргөдлийг цахимаар хүлээн авч бүртгэн, өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, эзэмших эрхийн гэрчилгээнд Э дугаар улсын бүртгэлийн газар луу захиалсан. 1 иргэний газар өмчлөх болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг улсын бүртгэлд захиалж гаргуулан бичилт хийж хувийн хэрэгт архивлаад байна.

2021.03.23-ны өдрийн А/22 тоот захирамжаар 4 дүгээр сарын 26-27-ны хооронд явагдах нийт 7 байршилд газрын дуудлага худалдааг зарлан цахим биржид зураг, байршил зарыг оруулсны дагуу, бүртгэлийн хугацаа эхэлж 4 сарын 19-ны өдрөөс эхлэн оролцогчдыг бүртгэж дуудлага худалдаанд цахим орчинд хэрхэн оролцох заавар зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллаж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

7 хоног бүрийн 3 дахь өдөр бүр мал төл бойжилт, хорогдолын мэдээг хүргүүлж ажиллаж байна.

Мод бут сөөг, төмс хүнсний ногооны захиалгыг албан байгууллага болон иргэдээс хүлээн авч ажиллаж байна.

Сумын хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг хориглож, хүнс барааны дэлгүүрийг 09-18 цагийн хооронд ажиллуулахыг аж ахуй нэгжийн дарга эрхлэгчдэд захирамж танилцуулсан.

Суманд өрхийн үйлдвэрлэл өргөжүүлэх, иргэдийн орлого ажлын байр нэмэгдүүлэх, иргэдийн орлого ажлын байр нэмэгдүүлэх, сумын бизнес орчинг сайжруулах зорилгоор сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдах хүсэлтэй иргэдийн 6 төслийг 2021 оны 03 сарын 17- оос 2021.03.31-ний өдрийг хүртэл хүлээн авсан.

Төсөв төрийн сангийн чиглэлээр:

2020 оны жилийн эцсийн Санхүүгийн нэгтгэсэн тайланг 2021 оны 3 сарын 5-25-ны дотор Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж баталгаажуулж, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланг тушааж “Зөрчилгүй” санал дүгнэлт авч ажилсан.

Орон нутгийн байгууллагуудын санхүүжилтийг хуваарилан залруулга бичилтүүдийг хийсэн.

Засгийн газрын 43 дугаар зардал хэмнэх тухай тогтоол гарсантай холбогдуулан зарим зардал хаагдсаныг төсөвт байгууллагуудын дарга эрхлэгч нарт танилцуулж, төсвийн хуваарийн дагуу зарлагын гүйлгээг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж гүйлгээг баталгаажуулж ажиллалаа.

Төсөвт байгууллагуудын 3 сарын гүйцэтгэлийн мэдээг 4 сарын 2-нд хуулийн хугацаанд хянаж баталгаажуулсан. Мөн өрийн мэдээг хүлээн авч программд шивж баталгаажуулсан.

Шилэн дансны сар бүрийн мэдээллийг 4 сарын 8-нд, жилээр жилийн эцсийн нэгтгэсэн тайлан болон дүгнэлтийг хуулийн хугацаанд 4 сарын 25-ны дотор мэдээлсэн.

